



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/157/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт.....	15
4.3 Албан шаардлага	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.09.29 № 2/20

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

• 005020558

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,140,196.00	35,120,567.00
33	АВЛАГА	15,330,000.00	00.00
335	Бусад авлага	15,330,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	15,330,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	26,810,196.00	35,120,567.00
354	Хангамжийн материал	26,810,196.00	35,120,567.00
35410	Бичиг хэргийн материал	226,000.00	288,000.00
35420	Аж ахуйн материал	16,826,946.00	23,658,317.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	120,000.00
35450	Барилгын засварын материал	925,000.00	384,500.00
35470	Бусад хангамжийн материал	8,832,250.00	10,669,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,157,625,046.45	7,022,396,234.32
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,157,625,046.45	7,022,396,234.32
392	Биет хөрөнгө	5,711,382,046.45	5,574,818,234.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,058,189,110.49	5,086,448,096.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	-257,024,568.60	-414,731,168.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	63,600,000.00	48,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-10,766,666.57	-15,116,666.63
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,090,676.00	71,770,096.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	-40,272,586.18	-46,004,975.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,546,187.00	83,507,187.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-45,090,105.69	-49,764,335.49
393	Биет бус хөрөнгө	1,446,243,000.00	1,447,578,000.00
39301	Програм хангамж	660,000.00	2,160,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-495,000.00	-660,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,199,765,242.45	7,057,516,801.32
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	26,338.18	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	26,338.18	00.00
413	Өглөг	26,338.18	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	26,338.18	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,199,738,904.27	7,057,516,801.32
51	Засгийн газрын хувь оролцоо	7,199,738,904.27	7,057,516,801.32
512	Хуримтлагдсан үр дүн	4,018,852,191.32	3,876,630,088.37
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-142,222,102.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,199,765,242.45	7,057,516,801.32

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,400,889,789.00	803,471,695.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	611,410,689.00	42,151,506.82
120	Нийтлэг татварын бус орлого	611,410,689.00	42,151,506.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	611,410,689.00	42,151,506.82
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,915,500.00	5,150,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	605,495,189.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/		36,099,506.82
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/		902,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	789,479,100.00	761,320,189.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	321,296,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	321,296,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,250,900.00	18,402,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,120,000.00	11,074,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,130,900.00	5,328,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	765,228,200.00	421,621,589.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	765,228,200.00	421,621,589.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	907,129,313.43	936,110,465.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	907,129,313.43	936,110,465.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	871,186,207.47	932,795,635.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,946,775.88	245,277,380.20
210101	Үндсэн цалин	240,946,775.88	245,277,380.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,291,324.34	30,798,395.45
210201	Тэтгэврийн даатгал	20,558,946.35	21,678,525.11
210202	Тэтгэмжийн даатгал	2,406,974.10	2,528,234.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,918,859.08	2,129,387.53
210204	Ажилгүйдлийн даатгал	400,597.09	408,737.83
210205	Эрүүл мэндийн даатгал	4,005,947.72	4,053,510.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	391,661,317.00	388,807,491.00
210301	Гэрэл, цахилгаан	4,121,134.00	4,019,519.00
210302	Түлш, халаалт	382,836,363.00	378,109,911.00
210303	Цэвэр, бохир ус	4,703,820.00	6,678,061.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,044,448.00	14,427,939.00
210401	Бичиг хэрэг	2,244,150.00	3,069,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,886,642.00	3,030,908.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	744,470.00	942,082.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	454,600.00	349,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,714,586.00	4,215,699.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	2,821,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,299,800.00	25,782,890.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	475,000.00	75,000.00
210604	Урсгал засвар	4,824,800.00	25,707,890.00
2107	Томилолт, зочны зардал	496,000.00	898,000.00
210702	Дотоод албан томилолт	496,000.00	898,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,202,853.00	11,083,456.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,479,053.00	6,922,976.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	00.00
210807	Газрын төлбөр	5,123,800.00	4,160,480.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	400,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,243,689.25	215,720,083.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,109,260.00	37,675,198.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	149,134,429.25	178,044,885.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,943,105.96	3,314,830.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,849,123.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,349,123.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	00.00

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	28,093,982.96	3,314,830.17
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	926,400.00	3,314,830.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	493,760,475.57	-132,638,769.53
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	9,583,333.42
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	9,583,333.42
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-9,583,333.42
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	493,760,475.57	-142,222,102.95

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	795,394,600.00	766,470,189.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,915,500.00	5,150,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,915,500.00	5,150,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,915,500.00	5,150,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,915,500.00	5,150,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	789,479,100.00	761,320,189.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	321,296,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	321,296,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,250,900.00	18,402,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,120,000.00	11,074,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,130,900.00	5,328,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	765,228,200.00	421,621,589.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	765,228,200.00	421,621,589.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	795,394,600.00	766,470,189.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	795,394,600.00	766,470,189.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	759,451,494.04	763,155,358.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,406,279.13	245,504,233.40
210101	Үндсэн цалин	219,436,571.51	245,504,233.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,969,707.62	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,709,482.91	30,597,880.43
210201	Тэтгэврийн даатгал	22,087,105.14	22,469,739.29
210202	Тэтгэмжийн даатгал	2,365,370.46	2,128,236.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,965,682.13	1,702,667.30
210204	Ажилгүйдлийн даатгал	446,266.57	390,581.05
210205	Эрүүл мэндийн даатгал	3,845,058.61	3,906,656.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	391,661,317.00	393,851,599.00
210301	Гэрэл, цахилгаан	4,121,134.00	4,019,519.00
210302	Түлш, халаалт	382,836,363.00	383,154,019.00
210303	Цэвэр, бохир ус	4,703,820.00	6,678,061.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,013,062.00	10,117,979.00
210401	Бичиг хэрэг	2,349,250.00	2,337,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,769,342.00	2,687,477.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	744,470.00	634,932.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	1,057,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,650,000.00	3,400,470.00

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,705,000.00	30,772,690.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	300,000.00	2,798,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	203,800.00
210604	Урсгал засвар	31,405,000.00	27,769,990.00
2107	Томилолт, зочны зардал	496,000.00	898,000.00
210702	Дотоод албан томилолт	496,000.00	898,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,832,953.00	18,276,556.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,109,153.00	14,116,076.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	00.00
210807	Газрын төлбөр	5,123,800.00	4,160,480.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	400,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,627,400.00	33,136,421.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,627,400.00	33,136,421.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,943,105.96	3,314,830.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,849,123.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,349,123.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		245,650.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		245,650.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,093,982.96	3,069,180.17
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	926,400.00	3,069,180.17
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	27,167,582.96	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	455,232,973.58	410,505,757.04	2,479,712,911.95	3,345,451,642.57
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	455,232,973.58	410,505,757.04	2,479,712,911.95	3,345,451,642.57
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	401,510,476.42	401,510,476.42
C08	2020 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	1,901,310,973.58	1,279,575,739.37	4,018,852,191.32	7,199,738,904.27
D01	2021 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	1,901,310,973.58	1,279,575,739.37	4,018,852,191.32	7,199,738,904.27
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,901,310,973.58	1,279,575,739.37	4,018,852,191.32	7,199,738,904.27
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-142,222,102.95	-142,222,102.95
D09	2021 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	1,901,310,973.58	1,279,575,739.37	3,876,630,088.37	7,057,516,801.32

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	762,917,800.00	744,998,908.83	17,918,891.17	97.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	762,917,800.00	744,998,908.83	17,918,891.17	97.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	762,917,800.00	744,998,908.83	17,918,891.17	97.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	245,627,500.00	245,504,233.40	123,266.60	99.9
210101	Үндсэн цалин	245,627,500.00	245,504,233.40	123,266.60	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,159,700.00	30,597,880.43	2,561,819.57	92.3
210201	Тэтгэврийн даатгал	23,334,600.00	22,469,739.29	864,860.71	96.3
210202	Тэтгэмжийн даатгал	2,456,300.00	2,128,236.09	328,063.91	86.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,965,100.00	1,702,667.30	262,432.70	86.6
210204	Ажилгүйдлийн даатгал	491,200.00	390,581.05	100,618.95	79.5
210205	Эрүүл мэндийн даатгал	4,912,500.00	3,906,656.70	1,005,843.30	79.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	408,851,300.00	393,851,599.00	14,999,701.00	96.3
210301	Гэрэл, цахилгаан	3,935,000.00	4,019,519.00	-84,519.00	102.1
210302	Түлш, халаалт	398,067,500.00	383,154,019.00	14,913,481.00	96.3
210303	Цэвэр, бохир ус	6,848,800.00	6,678,061.00	170,739.00	97.5
2104	Хангамж, бараа материалын зардал	10,120,900.00	10,117,979.00	2,921.00	100.0
210401	Бичиг хэрэг	2,337,600.00	2,337,600.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	2,687,500.00	2,687,477.00	23.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	635,000.00	634,932.00	68.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,060,300.00	1,057,500.00	2,800.00	99.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,400,500.00	3,400,470.00	30.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,774,200.00	30,772,690.00	1,510.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,800,000.00	2,798,900.00	1,100.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	204,200.00	203,800.00	400.00	99.8
210604	Урсгал засвар	27,770,000.00	27,769,990.00	10.00	100.0
2107	Томиллолт, зочны зардал	921,000.00	898,000.00	23,000.00	97.5
210702	Дотоод албан томиллолт	921,000.00	898,000.00	23,000.00	97.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураа	8,383,200.00	8,352,106.00	31,094.00	99.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний т	4,202,800.00	4,191,626.00	11,174.00	99.7
210807	Газрын төлбөр	4,180,400.00	4,160,480.00	19,920.00	99.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25080000.00	24904421.00	175,579.00	99.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,080,000.00	24,904,421.00	175,579.00	99.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	762,917,800.00	744,998,908.83	17,918,891.17	97.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	321,296,500.00	318,227,319.83	3,069,180.17	99.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	321,296,500.00	318,227,319.83	3,069,180.17	99.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	436,621,300.00	421,621,589.00	14,999,711.00	96.6
132001	Орон нутгийн төсвөөс	436,621,300.00	421,621,589.00	14,999,711.00	96.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	5,150,000.00	-150,000.00	103.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	5,150,000.00	-150,000.00	103.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27.00	27.00		
620001	Удирдах ажилтан	01.00	01.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00		
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00		
620004	Гэрээт ажилтан	06.00	06.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,166,400.00	18,402,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,166,400.00	18,402,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,240,000.00	18,156,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,240,000.00	18,156,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,240,000.00	9,924,450.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	8232000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	8,232,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	926,400.00	245650.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	926,400.00	245,650.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	926,400.00	245,650.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25,166,400.00	18402100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,166,400.00	18,402,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,120,000.00	11,074,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,046,400.00	5,328,100.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн ба тайлант жил хөрөнгө зарцуулахад нэгдүгээр гарын үсгийг дарга Б.Оюунбаатар, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Ч.Хандаа нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тив дэлхийн тэмцээн наадамд баг тамирчдыг бэлтгэн амжилттай оролцох
- Нийтийн биеийн тамирыг орон нутагт хөгжүүлэх.
- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Биеийн тамир спортын улсын хорооны дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 909,847.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,098.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,368.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 6,552.8 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 142,368.4 мянган төгрөгөөр буюу 2.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,140.2	35,120.6	(7,019.6)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	15,330.0	-	(15,330.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	26,810.2	35,120.6	8,310.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,157,625.0	7,022,396.2	(135,228.8)
Үндсэн хөрөнгө	7,511,274.0	7,548,673.4	37,399.4
Хуримтлагдсан элэгдэл	(353,648.9)	(526,277.1)	(172,628.2)
Нийт хөрөнгө	7,199,765.2	7,057,516.8	(142,248.4)
Өр төлбөр	26.3	-	(26.3)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,199,738.9	7,057,516.8	(142,222.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,199,765.2	7,057,516.8	(142,248.4)

Авлагын дансны үлдэгдэл 15,330.0 мянган төгрөгөөр буурсан нь 2020 онд Биеийн тамир спортын улсын хорооны даргын А/97 дугаар тушаалаар “Цахим фитнес” төслийг хэрэгжүүлэх зорилгоор Санко маркетинг ХХК-тай гэрээ байгуулан 9,990.0 мянган төгрөгийн үнэ бүхий ухаалаг самбар, Оал Селлер ХХК-тай гэрээ байгуулан 2,410.0 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжүүдийн үнийг шилжүүлсэн ч хүлээн аваагүй байсан тул авлагаар тусгасныг хүлээн авч хөрөнгөд бүртгэж авлагыг бууруулж бүртгэсэн.

Бараа материалын дансны үлдэгдэл 35,120.6 мянган төгрөг болж 8,310.4 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал дансны үлдэгдэл 62.0 мянга, аж ахуйн материал 6,831.4 мянга, бусад хангамжийн материал 1,837.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба урсгал төсвийн худалдан авалтаар аж ахуйн материал дээр 18,710.2 мянган төгрөгийн эд материал худалдан авсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,548,673.4 мянган төгрөг болж 37,399.4 мянган төгрөгөөр өссөн нь 5,450.0 мянган төгрөгийн хөрөнгийг бусад байгууллагын хандив тусламжаар, 2,390.5 мянган төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021.12.30-ны өдрийн 719 дугаар албан бичгээр Биеийн тамир спортын улсын хорооноос шилжүүлэн авч, урсгал төсвийн худалдан авалтаар 4,799.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 11,500.0 мянган төгрөгийн өртөг бүхий урд оны авлагаар тусгасан тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэсэн. Мөн байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 15,000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 9,583.3 мянган төгрөгийн үлдэх өртөг бүхий тээврийн хэрэгслийг Баянхонгор аймгийн ИТХ-ын 2021.09.06-ны өдрийн №96 тоот тогтоолоор Тэмүжин театрт шилжүүлсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,057,516.8 мянган төгрөг болж 142,222.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 142,222.1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,643,471.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,643,471.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 869,106.4 мянган төгрөгөөр бууруулж 774,365.2 мянган төгрөгөөр анх баталсан бөгөөд үүнд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 793,263.9 төгрөг буюу 370,965.2 мянган төгрөгөөр, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 394,491.9 мянга буюу 148,864.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 257,740.0 мянга буюу 231,660.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан нь тайлант онд усан бассейн цогцолбор болон 7 дугаар багийн спорт цогцолборын барилга ашиглалтад ороогүйтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 762,917.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 321,296.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 436,621.3 мянган төгрөгийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 321,296.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 421,621.6 мянган урсгал үйл ажиллагаанд 598,286.4 мянган төгрөгийг зарцуулж, 3,069.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 744,998.9 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 123.3 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 2,561.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 175.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 11,074.0 мянга, Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,000.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 5,328.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, зарцуулсан бөгөөд, үлдэгдэл 245.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь биеийн тамирын тэмцээн уралдааны төлөвлөгөөг Ковид-19 цар тахалтай холбоотойгоор оны эхэнд батлуулаагүй бөгөөд 2021 оны 5 дугаар сард байгууллагын дарга баталсан байна. Тус арга хэмжээнд нийт 24,333.4 мянган төгрөгийн санхүүжилтийг баталж, гүйцэтгэлээр 24,157.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2021 онд нийтийн биеийн тамир спортын 12 арга хэмжээ зохион байгуулж, 6636 хүн хамрагдсан байна. Мөн “Цахим гимнастрада” биеийн тамирын арга хэмжээнд нийт 57 багийн 578 хүүхэд, залуучууд, төрийн албан хаагч, ахмад настан хамрагдсан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Г.Ганчимэг санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 4 зорилтын хүрээнд 26 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 91.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 936,110.5 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 28,981.2 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 1,501,462.2 мянган төгрөгийн 83 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхээс хуулийн 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийн мэдээг 1,3 дугаар улирал, 6.4.4-д заасан таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 240,464.4 мянган төгрөгийн 5 мэдээлэл, 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 220,026.8 мянган төгрөгийн орлогын 6 гүйлгээ, 36,086.5 мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээг хугацаа хоцроосон бөгөөд 172,000.0 мянган төгрөгийн зарлагын 14 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг 774,365.2 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 11,447.4 мянган төгрөг хасаж баталснаас 321,296.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 436,621.3 мянган төгрөгийн мянган төгрөг, өөрийн орлогоор 5000.0 мянган төгрөг санхүүжүүлэхээр тодотгон баталсан.

- Албан томилолтын зардлыг 921.0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 898.0 мянган төгрөг зарцуулж 23.0 мянган төгрөг хэмнэсэн.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 422,298.7 мянган төгрөгөөр, тодотголоор 408,851.3 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 393,851.6 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 28,447.1 мянган төгрөг буюу 7.2 хувь хэмнэсэн.

- Бичиг хэргийн зардлыг 2,337.0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 2,337.0 мянган төгрөг зарцуулсан нь дээрх тогтоолтой нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 19,760.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,553.3 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 1,876.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 15,330.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийг бүрэн биелүүлж, 1753.9 мянган төгрөгийн Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар заалттай холбоотой 1 албан шаардлагыг аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанд шийдвэрлүүлэхээр өгсөн боловч хэрэгжээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар Баянхонгор аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020.04.08 ний өдрийн 131/ШШ2020/00463 тоот захирамжаар ажилгүй байсан хугацааны цалинд О.Загдсүрэнд 1601864 төгрөгийг цалингийн зардлаас 1601864 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас ажилгүй байсан хугацааны НДШ-д 152177 төгрөгийг төлсөн бөгөөд тус зөрчилд аймгийн СХАА-с биелэлтийг 2021.06.30-ны өдөр тооцохоо албан шаардлага хүргүүлсэн байна.

Дараагийн аудитаар албан шаардлагын биелэлтийг авч үзэхээр шийдвэрлэв.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 182,165.5 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс, 1,238.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,058.4 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 176,968.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 2,901.0 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Тайлант хугацаанд 1238.0 мянган төгрөгийн Pruis 30 автомашины сэлбэг хэрэгслийг бүртгэхдээ аж ахуйн материалд орлого авсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Ангилал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аж ахуйн материалд бүртгэсэн дээрх эргэлтийн хөрөнгийг сэлбэг хэрэгсэлд бүртгэж, залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Тайлант хугацааны зардлын гүйлгээг анхан шатны баримттай тулгахад биеийн тамирын уралдаан тэмцээний зардлаас зарцуулах нийт 856.5 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад байгууллагын дарга асан Н.Мэнджаргал 5 хоног ажилласан байхад зэрэг дэвийн нэмэгдлийг бүрэн тооцож 201.9 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийн мэдээг 1,3 дугаар улирал, 6.4.4-д заасан таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 240,464.4 мянган төгрөгийн 5 мэдээлэл, 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 220,026.8 мянган төгрөгийн орлогын 6 гүйлгээ, 36,086.5

мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээг хугацаа хоцроосон бөгөөд 172,000.0 мянган төгрөгийн зарлагын 14 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор”, 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 172,000.0 мянган төгрөгийн зарлагын 14 гүйлгээг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, албан шаардлага өгөв.

2. Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй УАЗ пургон автомашинд 3,370.0 мянган төгрөг, Приус-30 автомашинд 1,598.0 мянган төгрөгийн засвар үйлчилгээ хийсэн ч байгууллагын өмч хамгаалах зөвлөл үнэлгээ хийж, дүгнэлт гаргаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 “Худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх” 31.1.3.5 “Осол, гэмтэл гарсан шалтгааныг тогтоож, хэрэв тодорхой этгээдийн буруугаас уг осол, гэмтэл гарсан бол Иргэний хуульд заасан журмаар хохирлыг арилгуулах” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх хөрөнгийн урсгал засвартай холбоотой тооцооллыг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулах, цаашид алдаа зөрчлийг давтан гаргуулахгүй байх албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

1. Нийт ажилчдад 2021 оны 7 дугаар сард ур чадварын нэмэгдлийг Сангийн сайдын 2018 оны 382 дугаар тогтоолын хавсралт 4-д заасан шалгуур үзүүлэлтийг тооцолгүйгээр олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 4-д заасан шалгуур үзүүлэлтийг тооцолгүйгээр олгосон байгаа нь тус журмын 3 дахь “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

2. Шатахуун зарцуулалтын тайланг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын хамтарсан 2002 оны 171/111 дугаар тушаалаар баталсан маягтаар хөтөлсөн байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны "Маягт, заавар батлах тухай" 347 дугаар тушаалыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Сангийн сайдын 2017 оны "Маягт, заавар батлах тухай" 347 дугаар тушаалын холбогдох заалтыг мөрдөж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

3. Биеийн тамирын тэмцээн уралдааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тэмцээн, уралдааныг тэгш хүртээмжтэй зохион байгуулаагүй, төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байгаа зэрэг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид биеийн тамирын тэмцээн уралдааныг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тэгш хүртээмжтэй зохион байгуулж, төлөвлөгөөнд тусгагдаагүй спортын тэмцээн уралдааныг санхүүжүүлэхгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

4. Тус байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланг тулгахад анх 774,365.2 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021 оны 10 дугаар сард 11,447.4 мянга буюу 2.4 хувиар бууруулан 762,917.8 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг анх баталснаас 7.2 хувиар хэмнэсэн ч, бичиг хэргийн зардалд хэмнэлт гаргаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.6 "Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" 1.9 "Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар Засгийн газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж, бичиг хэрэг болон байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газар	9	182,165.5	1	1,238.0	2	1,058.4	2	176,968.0	4	2,901.1

_____оОо_____